

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР

ДОТООД АЛБАН БИЧИГ

№ 02/16

Огноо.2023.02.03

Хаанаас: Захиргаа, удирдлагын газар


Хаана: Нийт албан хаагчдад

Утга: Мэдээлэл хүргүүлэх тухай

Байгууллагын даргын 02 дугаар сарын 03-ны өдрийн А/33 дугаар тушаалаар "Хөдөлмөрийн дотоод журам"-д нэмэлт, өөрчлөлт орууллаа. Өдөр тутмын үйл ажиллагаандаа нэг мөр дагаж мөрдөхийг нийт албан хаагчид анхаарч ажиллана уу.

Хавсралт  хуудастай.

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА


Д.ДАВААНЯМ



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/33

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 10 дугаар зүйлийн 10.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2022 оны А/66 дугаар тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-д дараах нэмэлт, өөрчлөлт оруулсугай.

1. Журмын 5.24 дэх хэсгийн "...хугацаагаар" гэсний дараа "төрийн болон байгууллагын зардлаар, байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр" гэж нэмэх;
2. Журмын 5.20 дахь хэсгийг " Албан хаагчийн чөлөө хүссэн шалтгаан нөхцөлийг нь харгалзан дараах байдлаар чөлөөг олгоно:

Чөлөө олгох албан тушаалтан	Хэнд	Чөлөө олгох хугацаа	Чөлөө олгох баримт бичиг
Дарга	Нийт албан хаагчдад	10-60 хүртэл өдөр	Тушаал
	Зохион байгуулалтын нэгжийн дарга нарт	Ажлын 1-9 өдөр	Чөлөөний хуудас
Захиргаа, Удирдлагын газрын дарга	Албан хаагчдад	Ажлын 3-9 өдөр	
Төвийн нэгжийн дарга	Харьяалах нэгжийн албан хаагчдад	Ажлын 2 өдөр	
Боомт, орон нутаг дахь нэгжийн дарга	Харьяалах нэгжийн албан хаагчдад	Ажлын 1-5 өдөр	

" гэж өөрчлөн найруулах;

3. Журмын 5.22, 5.23 дахь хэсгийн "цалинтай" гэснийг "олговортой", 5.23 дахь хэсгийн "90 хоногоос" гэснийг "60 хоногоос" гэж тус тус өөрчлөх;

172301090

Хоёр. Энэ тушаал гарсантай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаалаар баталсан "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ыг мөрдөж ажиллахыг зохион байгуулалтын нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Н.УУГАНБАЯР